

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 03 дугаар сарын 17

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
----	---	--	---------------------------------------	------

**Үүрэг, даалгавар-НЭГ:** Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, хяналтыг сайжруулж ажиллах.

1.	<p>- Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл, арга хэмжээ, он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бэлтгэл ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 47</li> <li>- Тендерийн шатандаа байгаа төсөл арга хэмжээ – 43</li> <li>- Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 66</li> <li>- Ажил 100 хувь хийгдэж дууссан – 14</li> </ul> <p>Нийт хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн явцад тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн мэдээг 14 хоног тутамд шинэчлэн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	--	---	--	----

**Үүрэг, даалгавар ХОЁР:** Энэ онд хөрөнгө оруулалтаар шинээр тавьж байгаа цахилгаан, дулаан, цэвэр бохирын шугам сүлжээ болон тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудын талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлэх.

2.	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих цахилгаан, дулаан, цэвэр бохирын шугам сүлжээ болон тохижилт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийн хөрөнгө оруулалтын ажлын гэрээ байгуулагдах бүрт хорооны Засаг даргын ажлын албатай хамтран тухайн орчинд оршин суугч иргэд, ААНБ-үүд болон олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30
----	---	---	--	----

**Үүрэг, даалгавар ГУРАВ:** 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлууд эрчимжүүлж ажиллах.

3.	Дүүргийн засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны А/33 дугаар захирамжаар батлагдсан төсвийн орлогын хуваарийн дагуу дүүргийн төсвийн	=	Үүрэг даалгаврын	100
----	--	---	---------------------	-----

	орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 26 244 562.7 мянган төгрөг төвлөрөхөөс 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 10 682 951.1 мянган төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 40.75%-ийн гүйцэтгэлтэй байна.		хэрэгжилт хангагдана	
<b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах ажлын хүрээнд газар олголтын асуудлыг шуурхай шийдвэрлэж, газар чөлөөлөлтийн ажлуудыг эрчимжүүлж ажиллах.				
4.	<p>- Дүүргийн Засаг даргын 2021 оны A/431 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, тус дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт 55 нэгж талбарын судалгааг гарган, үнэлгээ хийх компанийтай гэрээ байгуулан иргэдтэй зөвшилцөх ажил хийгдэж байна. Дүүргийн Засаг Даргын 2021 оны A/448, A/450, A/453, A/464, A/473, 2022 оны A/56, A/89 дугаар бүхий долоон удаагийн захирамжаар 5,319,037,518 (Таван тэрбум гурван зуун арван есөн сая гучин долоон мянга таван зуун арван найман) төгрөг олгогдсон байна.</p> <p>Дүүргийн 10 дугаар хорооны газар чөлөөлөлтийн ажлын явц 2022 оны 03 дугаар сарын 15-ний өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар чөлөөлөлтөд өртсөн нэгж талбар - 55</li> <li>- Гэрээ байгуулсан нэгж талбар - 47</li> <li>- Гэрээ байгуулах шатандaa - 8</li> <li>- Гэрээ байгуулсан нэгж талбараас газраа бүрэн чөлөөлсөн – 40</li> </ul> <p>- Тус дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 112 нэгж талбарын судалгааг гарган, үнэлгээ хийх компанийтай гэрээ байгуулан иргэдтэй зөвшилцөх ажил хийгдэж байна. Дүүргийн Засаг Даргын 2021 оны A/453, A/464, A/473, A/515, 2022 оны A/56, дугаар бүхий таван удаагийн захирамжаар 3,766,091,979 (Гурван тэрбум долоон зуун жаран зургаан сая ерэн нэгэн мянга есөн зуун далан есөн) төгрөг олгогдсон байна.</p> <p>9 дүгээр хорооны газар чөлөөлөлтийн ажлын явц 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар чөлөөлөлтөд өртсөн нэгж талбар – 112</li> <li>- Гэрээ байгуулсан нэгж талбар - 31</li> <li>- Гэрээ байгуулах шатандaa – 8</li> <li>- Гэрээ байгуулсан нэгж талбараас газраа бүрэн чөлөөлсөн - 31</li> </ul>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

**Үүрэг, даалгавар ТАВ:** Сургууль, цэцэрлэгийн биеийн тамирын болон тоглоомын талбайн тоног төхөөрөмж, сүүдрэвч, орчны эдэлбэр газрын аюулгүй байдалд хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмолжуулан, хүүхэд бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

5.	<p>Хүүхдийг ахуйн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн гадна талбай, хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд осол гэмтэлд өртөж болзошгүй газруудын аюулгүй байдал, эрсдэлт нөхцөл байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсэг дүүргийн Засаг даргын 2022 оны A/53 дугаарын захирамжаар байгуулагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй 5 багаар, хяналт, шалгалт хийх ажлын удирдамж, төлөвлөгөө, хуваарийн дагуу хяналт, шалгалтын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд дүүргийн 1-19 дүгээр хорооны нийтийн эзэмшлийн тоглоомын талбай 43, Ерөнхий боловсролын сургууль 27, цэцэрлэг 57, нийт 127 байршилд хяналт, үнэлгээ хийхэд хүүхдэд эрсдэл бүхий зөрчилтэй цэцэрлэг 12, сургууль 3, нийтийн эзэмшлийн талбай 8, нийт 23 байршилд засвар үйлчилгээ хийж, хүүхдийн орчныг эрсдэлгүй болгох шаардлагатай байсан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах чиглэлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 3/462, 3/463, 3/493, 3/494 дугаар албан бичгээр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, холбогдох хороод, сургууль, цэцэрлэг зэрэг нийт 22 байгууллагад хүргүүлсэн.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
----	--	---	--	----


**Үүрэг, даалгавар ЗУРГАА:** Хүүхдийн бие эрхтэнд гэмтэл учруулж болзошгүй хурц үзүүр, ирмэгтэй болон бүрэн бүтэн байдал нь алдагдсан эрсдэл бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглахыг хориглох, зайлшгүй тохиолдолд бэхэлгээ, хаалт, хамгаалалт хийж, хяналт тавих ажилтныг томилох

6.	<p>Дүүргийн Засаг даргын A/53 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналт, шалгалтаар илэрсэн хүүхдийн бие эрхтэнд гэмтэл учруулж болзошгүй хурц үзүүр, ирмэгтэй, бүрэн бүтэн байдал нь алдагдсан эрсдэл бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий нийтийн эзэмшлийн талбайд засвар үйлчилгээ хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн дүүргийн нутаг дэвсгэр дэх 61 бичил цэцэрлэгийн цэвэрлэгээ үйлчилгээ, засварын ажлыг Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ компаниар тогтмол хийж гүйцэтгүүлэн ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	30
----	---	---	--	----

**Үүрэг, даалгавар ДОЛОО:** Ерөнхий боловсролын цэцэрлэг, сургуулийн орчинд болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд хүүхдийг зам, тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

7.	<p>Дүүргийн Сургууль, Цэцэрлэгүүд 10 хүртэлх насны хүүхэд, багачуудыг эцэг эхээс хүлээж авч, хичээл тараход эцэг эхчүүдэд гарын үсэг зурж, хүлээлгэн өгч "Гараас гар" хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p> <p>Сурагчдыг замын хөдөлгөөнд соёлтой, аюулгүй оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор замын 2 талд зам хөндлөн гараад сурагчдад туслах зорилготой "Шар дарцаг" аяныг хэрэгжүүлж байна.</p> <p>1-5 дугаар ангийн сурагчид цүнхний цацууллагч, ханцуйн цацууллагчийг тогтмол хэрэглэж хэвшсэн.</p> <p>Замын хөдөлгөөний аюулгүйн дүрэм, аюулгүй зорчих талаар сургуулийн болон эцэг эхийн цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээлэл хүргэн, мөн анги удирдсан багш нар сурагчид тарах үед 5 минут аюулгүйн дүрэм, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, авто замын тэмдэг, тэмдэглэгээний өнгө үзэмжийг сэргээх, далан суваг, борооны ус зайлцуулах шугам сүлжээний барилга байгууламж, гуу жалга нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах.				
8.	<p>Дүүргийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн зам талбай, авто замын тэмдэг, тэмдэглэгээний өнгө үзэмжийг сайжруулах, далан суваг, борооны ус зайлцуулах шугам сүлжээ, гуу жалга, нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас цэвэрлэгээний ажлыг Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компани, Найши трейд ХХК хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэж байна.</p> <p>Дүүргийн гэр хорооллын 7-19 дүгээр хороонд иргэдийн бүлгийн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлэг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж цэвэрлэгээний явцад нийт <b>21251 м2</b> талбайн <b>98</b> тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачилт хийн ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<b>Үүрэг, даалгавар ЕС:</b> Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангагдуулж, барилга угсралтын ажлын орчин тойрны өнгө үзэмжийг сэргээх.				
9.	<p>Чингэлтэй дүүрэгт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 25 аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт тавихад үйл ажиллагаа зогссон-15, дотор засал явагдаж байгаа-6, гадна фасадын ажил гүйцэтгэж буй-4 ААНБ байна.</p> <p>Барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй, дотор засал явагдаж байгаа 6 аж ахуй нэгжид гүйцэтгэлийн хяналт хийхэд шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хуулиар ажил олгогч хөдөлмөрийн гэрээ хийгээгүй, дотоод журам шинэчилж мөрдөөгүй зөрчил илэрсэн. Дээрх аж ахуйн нэгж байгууллагад Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2022.01.19-ний өдрийн 02-02/192 дугаар мэдэгдлийг хүргүүлж зөвлөгөө өгч ажилласан.</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	0

**Үүрэг, даалгавар АРАВ: Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлуудыг сайтар зохион байгуулах.**

10.	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн Онцгой комиссын даргын 2022 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг гаргаж, Онцгой байдлын хэлтсийн даргын 2022 оны "Хэрэгжилтийг ханган ажиллах тухай" 13.10 дугаартай албан бичгээр Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Тохижилт үйлчилгээний хэлтэс, Ногоон бүсийн 17, 19 дүгээр хороодын засаг дарга нар болон бусад хэлтэс албадын дарга наарт хүргүүлсэн.</p> <p>Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, голомтод ажиллах 12 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй 1 бүлгийг Онцгой байдлын хэлтсийн даргын 2022 оны A/15 дугаар тушаалаар томилгоожуулан ногоон бүсийн 17 дугаар хороо Чингэлтэй хайрхан, Зүрх-уул, Залаатын ам, 19 дүгээр хороо Шадивлан, Яргайт, Жигжид /моби/, Жигжид /аранзат/, Жигжид /гүнт/, Майхан толгой, Санзай, Халзангийн даваа зэрэг амуудад хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p>Ой, хээрийн гал түймэр унтраах багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангах хүрээнд үлээгч аппарат 30 ширхэг, зөөврийн ус шуршигч 24 ширхэг, трессон шүүр 180 ширхэг, цохиур 150 ширхэг, хүрз 80 ширхэг, сух 10 ширхэг, хөрөө 12 ширхэг, цуравдагч 8 ширхэг зөөврийн гэрэл, мотортой 1 ширхэг зэрэг бэлэн байдлын нөөцийг бурдуулэн ажиллалаа.</p>	 <span style="font-size: 1.5em;">=</span>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	<p>100</p>
-----	---	---	--	------------

ДАРГА

Н.БАТСУМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭДИЙН ЧИНГЭЛТЭЙ ДААРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Н.ХАНГАЙ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

  
М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭССЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Д.ДОЛГОРМОАА